

Улсын бүртгэлийн
дугаар.....

Нууцын зэрэглэл

Аравтын бүрэн.
Ангиллын код

Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар:
Шу Сс-2019/61

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

“МОНГОЛЫН УГСААТАН СУДЛАЛЫН ТҮҮХ: НҮҮДЭЛЧИД БА ШИНЖЛЭХ УХААН”

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

/2019-2022/

Төслийн удирдагч:

Г. Цэрэнханд – Угсаатан судлалын ухааны
доктор (PhD), профессор

Төслийн гүйцэтгэгч:

С. Чулуун – Академич
Ц. Цэрэндорж – Доктор (PhD), дэд профессор
Ч. Батдорж - Доктор (PhD)
Н. Мягмар - Доктор (PhD)
Н. Маралмаа - Доктор (PhD)
Г. Бямбарагчаа – Докторант
Ч. Мөнхтөр – Докторант
М. Энхбаатар – Докторант

Санхүүжүүлэгч байгууллага:
Захиалагч байгууллага:

БШУЯ-ны Шинжлэх ухаан Технологийн сан
Боловсрол, шинжлэх ухааны яам

Гүйцэтгэгч байгууллага:

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
Баянзүрх дүүрэг 14-р хороо, Жуковын гудамж,
ШУА-н байр
Утас: 11-458305, 455028
Факс: 11-458305
Цахим шуудан: info@history.mas.as.mn

Улсын бүртгэлийн
дугаар.....

Нууцын зэрэглэл

Аравтын бүрэн.
Ангиллын код

Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар:
Шу Сс-2019/61

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

“МОНГОЛЫН УГСААТАН СУДЛАЛЫН ТҮҮХ: НҮҮДЭЛЧИД БА ШИНЖЛЭХ УХААН”

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

/2019-2022/

Төслийн удирдагч:

Г. Цэрэнханд – Угсаатан судлалын ухааны
доктор (PhD), профессор

Төслийн гүйцэтгэгч:

С. Чулуун – Академич
Ц. Цэрэндорж – Доктор (PhD), дэд профессор
Ч. Батдорж - Доктор (PhD)
Н. Мягмар - Доктор (PhD)
Н. Маралмаа - Доктор (PhD)
Г. Бямбарагчаа – Докторант
Ч. Мөнхтөр – Докторант
М. Энхбаатар – Докторант

Санхүүжүүлэгч байгууллага:

БШУЯ-ны Шинжлэх ухаан Технологийн сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Гүйцэтгэгч байгууллага:

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн
Баянзүрх дүүрэг 14-р хороо, Жуковын гудамж,
ШУА-н байр
Утас: 11-458305, 455028
Факс: 11-458305
Цахим шуудан: info@history.mas.as.mn

Агуулга

Оршил

Удиртгал

Сэдэвт ажлын зорилго

Сэдэвт ажлын шинэлэг тал

Сэдэвт ажлыг гүйцэтгэх болсон үндсэн шаардлага

Сэдвийн хүрээнд төлөвлөсөн ажил

Судалгааны гол үр дүн

Судалгааны үр дүнг сурталчилсан байдал

Судалгааны үр дүнг хэвлүүлсэн байдал

Дүгнэлт

Хавсралт

Оршил:

Монгол Улсын БШУЯ-ны захиалга, ШУТС-ийн санхүүжилтээр “Монголын угсаатан судлалын түүх: Нүүдэлчид ба шинжлэх ухаан” суурь судалгааны төслийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнд 2019-2022 онд амжилттай гүйцэтгэв.

Удиртгал

XX зууны монгол дахь шинжэх ухааны түүхэн хөгжил бүхэлдээ зогсолтгүй урагшилсан түүхэн хөгжил, судалгаа, эрдэм судлалын тасралтгүй үйл явц, үндэсний мэргэжлийн судлаачид төрөн гарч, Үндэсний өвөрмөц онцлог хийгээд дэлхий нийтийн шинжлэх ухааны хөгжлийг даган үндэсний судалгааны бүхэл бүтэн систем, бүтэц, зохион байгуулалтыг бий болгосон он жилүүд байв. Өнгөрсөн зууны монгол дахь шинжлэх ухааны хөгжил ба түүний үйл явцын түүхий гурван зүйлд багцалж болно. Үүнд:

1. XX зууны эхэн үед Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан он жилтэй зэрэгцэн өөрийн гэсэн шинжлэх ухааны тогтолцооны тулгын чулууг тавьж, Монгол үндэстэн өөрөө өөрийгээ судлан шинжлэх, байгаль орчлон ертөнцийн үүсэл гарвал, хүмүүний үүсэл гарвал, байгаль, хүрээлэн буй орчин судлал зэрэг олон талын судалгааг үндэсний мэргэжилтэнгүүдийн хүч хөдөлмөрөөр судлан шинжилж эхэлсэн нь өнөөгийн шинжлэх ухааны хөгжлийн эхлэлийг тавьсан үйл явдал болсон юм.

2. Капитализмын өмнөх үеийн нийгмийн харилцаанд байсан Монгол орон XX зуунд бүх нийтээрээ бичиг үсэгт суралцаж, улмаар орчин үеийн шинжлэх ухааны нэгдсэн тогтолцоог үүсгэн хөгжүүлж, төлөвшүүлэн, үндэсний мэргэжлийн судлаач, эрдэм судлалын сэхээтэн, судлаачдыг сурган бэлтгэж эхэлжээ. Түүнчлэн тус улсад шинжлэх ухааны олон салбар өргөжиж хөгжиж, эрдмийн зэрэг цолтой үндэсний судлаачид төрөн гарч, тэдний судалгаа, бүтээлүүд хэвлэгдэн, үйлдвэрлэлд нэвтрэх болжээ.

3. XX зууны хоёр дугаар хагасаас Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны бүтэц, тусгай систем бий болж, тэр хирээр олон талын шинжлэх ухааны салбар ухаануудын хөгжлийн шанг татаж, Монгол улс орчин үеийн шинжлэх ухаанцсан улс болон хөгжиж чадсан байна.

XX зууны эхэн үеэс бий болж, хөгжиж эхэлсэн Монголын шинжлэх ухааны салбарын хөгжил нь нүүдэлчин монголчуудын ертөнцийг үзэх үзлийг бүхлээр нь өөрчлөх нэгэн том шалтгаан болж, аливааг зөвхөн шашин, шүтлэгийн үүднээс тайлбарлаж ирсэн олон зууны жилийн итгэл үнэмшлийг орчин үеийн дэлхийн олон улс

түмний хөгжлийн жишгээр аливааг шинжлэх ухаанч, объектив байдлаар тайлбарлаж сурахад гол үүрэг гүйцэтгэсэн үйл явдал болсон юм. Монголын шинжлэх ухааны салбар ухаанууд, ялангуяа бидний сонгон авсан угсаатан судлалын салбар ухааны хөгжил нь Монгол хүн, Монголчууд гэж хэн болох, түүний өнгөрсөн түүхэнд туулж ирсэн түүхэн үйл явц хийгээд бүс нутаг, ахуй байдлаас үүдэн бий болсон соёлын олонлогийг үндэсний мэргэжлийн угсаатны зүйчид анхааран судалж, Монгол загварын үндэсний хэмжээний томоохон бүтээл туурвилуудыг 1950-аад оны төгсгөл үеэс хойш шил дараалан олноор гаргах болов. Хэдийгээр ХХ зууны монголын угсаатан судлалын салбар ухааны хөгжил дэлхийн олон орны нийтлэг хөгжлийн дагуу явж эс чадан, олон улсын нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан харьцангуй хаагдмал, зөвхөн нэг хоёр улстай өргөн харилцаж, бусад улсуудтай төдий л гүн харилцаатай байгаагүй нь судалгаа, эрдэм шинжилгээний чанарт тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан хэдий ч түүнийг үндэсний мэргэжлийн судлаачид эерэгээр ашиглаж, үндэсний хэмжээний судалгааны төслийг тасралтгүй явуулж байсан нь өдгөө энэ чиглэлийн судалгаанд үнэлж баршгүй үнэт өвийг бий болгох үндэс суурь нь болсон юм.

ХХ зууны эхэн үеэс бий болж, хөгжиж ирсэн монголын угсаатан судлалын салбар ухаан нь олон зуун жилийг нүүдлийн амьдралаар амьдарч ирсэн нүүдэлчин монголчуудын уламжлалт амьдралын хэв маягийг хамгийн то судлагдахуун болгож, түүний мөн чанар, уламжлалт технологи, амьдралын орчин дахь олон талын нийтлэг болоод бусдаас ялгарах өвөрмөц хэв төрхийг судлан шинжилж, түүний үр дүнг олон улсад тайлбарлан таниулахад гол үүрэг гүйцэтгэсэн нь монголын угсаатан судлаачид болоод тэдэнтэй хамтран ажиллаж асан гадны олон улсын судлаачид байсныг дурдах нь зүй ёсны хэрэг болно. монголчууд дэлхийд танигдаж, тусгаар улсаа батлан тунхаглаж, нүүдлийн мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болж, нийгэм соёл боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн чанарын цоо шинэ түвшинд хүрч чадсан юм.

Иймд, өнгөрсөн зууны эхнээс үүсэлтэй монголын угсаатан судлалын салбар салбар ухааны түүхийг судлан үнэлгээ дүгнэлт өгөх нь энэ талын судалгаа, сургалт явуулж буй олон арван эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, төрийн болон хувийн хэвшлийн олон арван байгууллагуудын түүхэн хөгжил, түүний ирээдүйн хандлага, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ монголын шинжлэх ухааны хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодруулах, удирдан чиглүүлэхэд зайлшгүй

шаардлагатай уялдуулан шинжлэх ухаан судлалын үүднээс тайлбарлан, өнгөрсөн одоо, ирээдүйн 3 цагийн уулзвар дээрээс шинээр үнэлэн дүгнэлт өгөх зорилгоор суурь судалгааны төслийн багийн гишүүд ажиллав.

Сэдэвт ажлын зорилго: Монгол дахь угсаатан судлалын салбар ухааны түүхэн хөгжил, үйл явц, онол арга зүйн хөгжил, судалгааны түүхэн хөгжил, монгол дахь угсаатан судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургууль, хүрээлэн, төвийн үйл ажиллагаан дахь угсаатан судлалын чиглэлийн судалгааны түүхэн үйл явцыг шинжлэх ухаан судлалын үүднээс нэгтгэн судлах замаар шинэ мэдлэг бүхий бүтээл туурвихад оршино. Үүний тулд дараах зорилтуудыг шийдвэрлэсэн болно.

А. Шинжлэх ухаан судлал хэмээх салбар ухаан, түүний зүгээс угсаатан судлалын салбар ухааныг үнэлж дүгнэх, түүний түүхэн хөгжлийг тодруулах,

Б. Монгол дахь угсаатан судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их дээд сургууль, хүрээлэн, төвүүдийн үйл ажиллагаа, судалгааны чиглэлүүдийн онцлог, ач холбогдол, судалгааны гол бүтээлүүдийг тодруулах,

В. Монголд шинжлэх ухаан судлалын чиглэлээр аливаа салбар шинжлэх ухааныг дахин судлах, түүний түүхэн хөгжил онол арга зүйн талаарх судалгаа явуулж судалгааны баазыг өргөжүүлэх.

Сэдэвт ажлын шинэлэг тал:

1. Монгол дахь угсаатан судлалын салбар ухааныг шинжлэх ухаан судлалын үүднээс анх удаа авч үзэж, олон талын эх сурвалжийг ашиглан, түүхэн зарчмыг удирдлага болгон цогц байдлаар авч үзэж, тал бүрээс нь судлан үнэлж дүгнэх,

2. Тухайн сэдвээр монгол дахь шинжлэх ухааны хөгжлийн түүхийг дахин судлах, түүний хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох, энэ талын судалгааны баазыг өргөжүүлэх,

3. Тухайн сэдэвт холбогдох баримтууд, гадаад дотоодын архивуудад хадгалагдаж буй баримтуудыг зэргийг шинээр илрүүлж судалгааны эргэлтэнд оруулах,

4. Судалгааны үр дүнд үндэслэн төрөөс шашны талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны талаар санал дүгнэлт дэвшүүлсэн зэрэг болно.

Сэдэвт ажлыг гүйцэтгэх болсон үндсэн шаардлага:

Нэгд: Монгол Улсын төрөөс шинжлэх ухааны талаар баримтлах бодлого, үндэсний түүх, шашин соёлын судалгааг өргөжүүлэх талаар үндсэн баримт бичигт дэвшүүлсэн заалтуудыг үндэс болгов.

Хоёрт: Монголын шинжлэх ухааны салбарт өдгөөг хүртэл огт судлагдаагүй байсаар ирсэн нэгэн асуудал бол шинжлэх ухаан судлалын асуудал болно. Монголд шинжлэх ухааны байгууллага байгуулагдаад даруй 100 гаруй жилийг өнгөрч байгаа хэдий боловч шинжлэх ухаан судлал буюу шинжлэх ухааны түүхэн хөгжил хийгээд онол арга зүйн түүхэн хөгжил, хувирал, өөрчлөлт, нийгэм дэх үүргийн талаарх системтэй судалгаа өдийг хүртэл хийгдээгүй байсаар байна. Хэдийгээр шинжлэх ухаан судлалын чиглэлээр их бус ч тодорхой хэмжээгээр онолын цөөн хэдэн бүтээл өнгөрсөн ХХ зууны туршид хэвлэгдэн гарсан хэдий боловч төдий л нийтийн хүртээл болж чадалгүй явсаар иржээ. Тэр дундаа шинжлэх ухааны түүхэн хөгжлийн талаарх нэгдсэн онол, үзэл баримтлалын хүрээнд авч үзэж, нийгэм дэхь шинжлэх ухааны гүйцэтгэх үүрэг, роль зэрэг олон асуудлуудыг хөндсөн судалгааны бүтээл төдий л их бус байна.

Монголын түүхийн судалгааны нэгэн том салбар ухаан болон хөгжсөөр ирсэн угсаатан судлалын ухаан нь монголд хөгжиж эхлээд бараг 100 гаруй жил болж байгаа бөгөөд монголын шинжлэх ухааны ууган байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагааны нэг чиглэл нь ард түмний ахуй байдлыг судлах буюу угсаатан судлалын салбар ухаан байв. Түүнээс хойш 1950-аад оноос хойш үндэсний мэргэжлийн судлаачид төрөн гарах болсон нь тус салбар ухааны хөгжлийн шинэ шатыг гаргаж, судалгаа, эрдэм судлалын хөгжилд том байр суурь эзлэх болжээ. Өнгөрсөн 60 гаруй жилийн хугацаанд монголын угсаатан судлалын салбар ухаан хөгжсөн нь энэ чиглэлийн судалгааны олон арван ном бүтээлүүд хэвлэгдэн, олны хүртээл болсоор ирсний нэгэн жишээ болно. Ийм учраас Монголын угсаатан судлалын ухааны түүхэн хөгжлийг дахин судлах шаардлагатай байв.

Сэдвийн хүрээнд төлөвлөсөн ажил:

“Монголын угсаатан судлалын түүх: Нүүдэлчид ба шинжлэх ухаан” (ШуСс_2019/61) суурь судалгааны төслийн даалгаварт:

1. “Монголын угсаатан судлалын шинжлэх ухааны түүх” (20 х.х) нэгэн сэдэвт хамтын бүтээл
2. Эрдэм шинжилгээний өгүүлэл 5 (3-5 х.х)-г бичиж нийтлүүлэхээр тусгасан болно.

Суурь судалгааны төслийн зардал нь эрдэм шинжилгээний ажлын зардал, хөдөө орон нутгийн архивт томилолтоор ажиллах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, төсөлд гэрээгээр оролцогчдын цалин, судалгааны ажлын үр дүнг хэвлэн нийтлэх, сэдэвт ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт, магадлагаа хийлгэх зэрэг зардлаас бүрдсэн бөгөөд нийтдээ 38,000,000 төгрөгийн санхүүжилт хийхээр гэрээнд тусгаж, санхүүжилтийг бүрэн авч гэрээнд заасны дагуу зарцуулав. Үүнд, 2019 онд 6,435,000 төг, 2020 онд 8,000,000 төг, 2021-2022 онд 23,500,000 төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

Суурь судалгааны төслийн ажил гэрээнд зааснаар 2021 онд дуусах байсан боловч цар тахлын нөхцөл байдалтай уялдан хугацааг нэг жилээр сунгаж, 2022 онд дуусган үр дүнг захиалагчид хүлээлгэн өгч байна.

Үндсэн бүлэг:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд сэдэвт холбогдох эх сурвалжуудыг нягтлан судлахад гол анхаарлаа хандуулан юуны түрүүнд Монгол Улсын Үндэсний Төв Архивын Түүхийн баримтын архив (МУУТА-ын ТБА), ОХУ-ын Буриад улсын төв архив, Эрхүүгийн төв архив, Улаан-Үүдийн архив зэрэгт судалгаа явуулав.

Суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэхдээ судалгааны дараах арга зарчмыг баримтлав. Үүнд:

Нэгдүгээрт: Марксист түүх бичлэг ноёрхож байх үеэс уламжлагдан ирсэн үзэл сурталч, догматик байдлаар түүхэнд хандах, түүх бичлэгт цаг үеийн үзэл суртлын байдалд нийцүүлэн цагаан толбо үлдээх, түүхийг эзэнгүйдүүлэх байдлыг халж, тухайн түүхэн тодорхой нөхцөлд, хүмүүсийн оюун билгийн түвшинд нь асуудлыг “түүхэн историзм”-ын үүднээс шинжлэн судлах арга зүйн шинэлэг хандлагыг баримтлав.

Хоёрдугаарт: Монголын угсаатан судлалын салбар ухааны түүхэн хөгжлийг институтчилэгдсэн байдлаас хүн төвтэй харж, хувь судлаачийн бүтээл, туурвилын

онцлог тал, онол арга зүйн шинэ хандлага талаас нь тодруулахыг оролдсон. Мөн шинжлэх ухааны түүхэн хөгжлийг нийгмийн талаас нь авч үзэх, нийгэм дэх үүрэг талаас нь тодорхой хэмжээгээр тайлбарлах оролдлогыг хийсэн нь шинэлэг судалга болсон байна.

Гуравдугаарт: Монголын шинжлэх ухааны нэгэн томоохон салбар болсон угсаатан судлалын ухааны түүхэн хөгжлийг тодруулан ажиллахдаа түүхэн хүн болоод аль нэг байгууллагын үйл ажиллагааг нэг бол хэт үнэлдэг, эсвэл гадаад хүчин зүйлийг хэт шүтдэг “туйлшрах” хандлагаас зайлсхийж, түүхэн талаасаа шинжлэх ухааны хөгжилд нийгэм, эдийн засгийн үйл явцад нөлөө үзүүлсэн дотоод, гадаад хүчин зүйлийг тэнцвэртэй авч үзэхийг эрмэлзэв.

Дөрөвдүгээрт: Түүхэн зарчмын гол үндэс болсон түүхэн баримт нотолгоонд үндэслэх аргыг гол болгож, урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй шинэ баримтуудыг илрүүлэн судалгааны эргэлтэд оруулах, аливаа түүхэн үзэгдэл үйл явдлыг баримтад тулгуурлан үнэлж дүгнэх аргыг баримтлав.

Судалгааны гол үр дүн: Суурь судалгааны үрдүнгээр “Монголын Угсаатан судлалын түүх” нэгэн сэдэвт хамтын бүтээлийг бичиж 2023 оны 1 дүгээр сард хэвлэлд шилжүүлэхэд бэлэн болгоод байгаа бөгөөд одоогийн байдлаар ерөнхий редакторын сүүлийн уншилтыг хийж байна. Энэхүү бүтээлийг туурвихдаа шинжлэх ухаан судлал гэж юу болох, угсаатан судлалын салбар ухааны түүхэн тойм, Монгол дахь угсаатан судлалын салбар ухааны үүсэл, хөгжил, үндэсний мэргэжилтэн бэлтгэгдэн гарсан үе, анхны судалгааны бүтээлүүд гарч эхэлсэн ХХ зууны дун үеийн угсаатан судлалын судалгааны чиглэл, онол үзэл баримтлал бүрэлдэн тогтож эхэлсэн тухай, үндэсний мэргэжилтэн бэлтгэгдэн гарч эхэлсэн ХХ зууны төгсгөл үе дэх угсаатан судлалын судалгаа, онол үзэл баримтлал дахь өөрчлөлт, дэлхий дахины угсаатан судлалын чиглэлийн судалгаа зэрэг олон талын үүднээс судлахыг зорьсон бөгөөд юуны түрүүнд,

- Шинжлэх ухаан судлал ба угсаатан судлалын ухааны түүхэн хөгжлийн тойм, монголын шинжлэх ухааны ууган байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгээс угсаатан судлалын талаар явуулсан судалгааны талаар,

- Монгол дахь угсаатан судлалын ухааны анхны мэргэжлийн судлаачид төрөн гарсан талаар, тухайн үеийн монгол дахь угсаатан судлалын чиглэлийн судалгаа, онол үзэл баримтлалын талаар,

-XX зууны төгсгөл үед монголд анхны мэргэжилтэн бэлтгэн гаргах болсон, угсаатан судлалын онол үзэл баримтлалд дэлхийн олон улсын судалгааны чиглэл, онолын чиг баримжаа нэвтрэн орж ирэх болсон, судалгааны чиглэл илүү өргөн хүрээг хамарч, төрийн болоод төрийн бус байгууллага, хүрээлэн, их дээд сургуулиудад төслийн судалгааг түлхүү явуулж эхэлсэн тухай,

- Дэлхийн олон оронтой хамтран үндэсний болон олон улсын хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлж эхэлсэн тухай,

- Монголын угсаатан судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүрээлэн, их дээд сургуулиудын гадаад дотоод хамтын ажиллагаа зэрэг асуудалд гол анхаарлаа хандуулав. Өөрөөр хэлбэл, монголын угсаатан судлалын салбар ухааны хөгжлийг аль болох өргөн хүрээгээр, олон улсын болоод дотоод хүчин зүйлсийн хүрээн дунд авч үзэхийг хичээсэн бөгөөд тэр дундаа судалгааны онол, үзэл баримтлалын өөрчлөлт, дэлхий нийтийн судалгааны чиг хандлагыг хэрхэн хүлээн авсан зэрэг аль болох өргөн хүрээнд судлахыг хичээв. Үүний тулд судлагдахуунаа ямар нэг онол, бодлогын үүднээс харж тайлбарлах бус гагцхүү баримт нотолгоонд тулгуурлан, түүхэн судалгааны аргаар бодит байдлыг нэхэн тодруулах зарчмыг баримталсан болно. Мөн бүтээлийг туурвихдаа дээр дурдсан архивуудын баримт болон судалгааны бүтээлүүд, түүнчлэн аман түүхийн мэдээ, байгууллагын түүх, олон улсын болоод үндэсний хэмжээний төслийн судалгааны үр дүн, холбогдох ном бүтээл зэрэг олон талын баримт, мэдээллийг ашиглав. Архивын баримтууд нь ихэвчлэн анх удаа судалгааны эргэлтэд орж буй шинэ баримтууд юм.

Угсаатан судлалын салбар ухааны түүхэн хөгжлийг үндэсний хэмжээний бүхий л түвшний судалгааны байгууллага, их дээд сургуулиудын явуулж ирсэн түүхэн хөгжлийн асуудлыг анх удаа өргөн хүрээнд судалсан энэхүү нэгэн сэдэвт зохиол нь удиртгал, 4 бүлэг, 11 зүйл, дүгнэлт, хавсралт, ном зүйгээс бүрдэнэ. Удиртгалд, энэхүү сэдэвт ажлын талаар товч дурдаж, сэдвийн судлагдсан байдал, судалгааны зорилго, зорилтыг тодорхойлов.

Нэгдүгээр бүлэгт, шинжлэх ухаан судлал гэж юу болох талаар, Монголын шинжлэх ухааны ууган байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгээс угсаатан судлалын чиглэлээр явуулсан үндэсний болоод гадаадын судлаачидтай хамран хэрэгжүүлж байсан судалгааны талаар өгүүлэв.

Хоёрдугаар бүлэгт, Монголд угсаатан судлалын үндэсний мэргэжлийн судлаачид төрөн гарч, анхны томоохон хэмжээний хээрийн судалгааг системтэйгээр хийж эхэлсэн, хээрийн судалгааны арга зүй хэлбэршн тогтож эхэлсэн, тухайн үеийн судалгааны томоохон бүтээлийн талаар түүхийг бичив.

Гуравдугаар бүлэгт, ХХ зууны төгсгөл үеэс судалгааны онол, арга зүйн шинж чиг хандлага бий болж эхэлсэн, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс хэрэгжүүлж байсан томоохон хэмжээний судалгааны төсөл хөтөлбөрүүд, монгол дахь бусад их дээд сургуулиуд болон судалгааны байгууллагуудын угсаатан судлалын чиглэлээр явуулсан бодлого үйл ажиллагааны талаар, томоохон судалгааны бүтээлүүдийн талаар өгүүлэв.

Дөрөвдүгээр бүлэгт, гадаадын монгол судлаачдын монголын угсаатан судлалын чиглэлээрх судалгааны түүхэн хөгжлийг тойм байдлаар өгүүлсэн бөгөөд Оросын монгол судлаачдын монгол дахь угсаатан судлалын чиглэлийн судалгаа, Азийн зарим улсуудын судлаачдын монголын угсаатан судлалын чиглэлийн судалгаа, гол бүтээлүүд, Евро-Америкийн судлаачдын монголын угсаатан судлалын чиглэлийн судалгаа, онол арга зүйн онцлог, гол бүтээлүүдийн талаар нэгтгэн өгүүлэв.

Бүтээлийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Гавъяат ажилтан, Доктор (Ph.D), профессор Г. Цэрэнханд, академич С. Чулуун нар редакторлав. Энэхүү бүтээл нь монгол дахь угсаатан судлалын салбар ухааны хөгжлийг шинжлэх ухаан судлалын үүднээс нэгтгэн, системийнх нь түүхийг нэгтгэн гарч буй анхны бие даасан бүтээл бөгөөд бүх шатны сургалт, эрдэм шинжилгээний ажилд ашиглах боломжтой юм.

2020 оны 02 сарын 05-нд ШУТсангаас 2019-2021 онд хэрэгжүүлж буй суурь судалгааны төслийн мониторингийн хурлыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар хийсэн. Тус хурлаал ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс хэрэгжүүлж буй “Монголын угсаатан судлалын түүх: Нүүдэлчид ба шинжлэх ухаан” Суурь судалгааны сэдэвт ажлын явцыг хангалттай гэж дүгнэсэн бөгөөд сэдэвт ажлын үр дүнд хэвлэгдэхээр төлөвлөж байсан нэг хамтын бүтээл болох “Гадаадын монгол судлаачдын Монголын угсаатны судалгаа” бүтээлийг санхүүжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан “Монголын угсаатан судлалын түүх” хамтын бүтээлд оруулахаар ШУТсангаас санал гаргаж шийдвэрлэв.

2022 оны 11 сарын 02-нд ШУТсангаас 2019-2022 онд хэрэгжүүлж буй Төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх ажлын хүрээнд Боловсрол Шинжлэх ухааны яам, ШУТсангийн шинжээчид, МУИС, МУБИС-ийн багш нараас бүрдсэн баг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс хэрэгжүүлж буй төслүүдийн явцтай танилцаж, тус төслийн эрдэм шинжилгээний ажил болон санхүүгийн тайлантай танилцаж, “Монголын угсаатан судлалын түүх: Нүүдэлчид ба шинжлэх ухаан” Суурь судалгааны төслийн явцын гүйцэтгэлийг 100 хувьтай байна гэж дүгнэв.

Судалгааны үр дүнг сурталчилсан байдал: Монголын угсаатан судлалын салбар ухаанд гол үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн судлаачдын хээрийн судалгааны үеэр авсан гэрэл зургуудыг нэгтгэн цувралаар “Монголын угсаатан судлаачдын гэрэл зургийн өв” катологийг 2020 оноос эхлэн гаргаж эхэлсэн бөгөөд уг бүтээлд монголын анхны мэргэжлийн угсаатан судлаачдын хээрийн судалгааны үеэр авсан гэрэл зургуудыг нэгтгэн анх удаа олны хүртээл болгон гаргаж эхэлсэн. Уг бүтээлийн анхны дугаарт ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Гавъяат ажилтан, Доктор (Ph.D), профессор Г. Цэрэнхандын 1960-1990-ээд оны үеэр авсан нийт 200 гаруй гэрэл зургуудыг нэгтгэн “Монгол малчдын нүүдэл нутагшил” нэртэйгээр 2021 онд хэвлүүлсэн бөгөөд энэхүү цуврал нь монголын угсаатан судлалын шинжлэх ухааны үүсэл хөгжил, судалгааны арга зүй зэрэг олон талын мэдээллийг агуулдагараа ач холбогдолтой бүтээл болсон юм. 2 дахь дугаарт 1962-1972 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Этнографийн тасагт эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байсан Ц. Гочоогийн 1962-1967 онд Архангай, Хөвсгөл, Дорнод, Сүхбаатар, Төв, Өвөрхангай аймгуудын нутагт хээрийн судалгаа хийж байхдаа авсан 270 гаруй гэрэл зургуудыг нэгтгэн “Зургуудын дурсамж: XX зууны дунд үеийн Монголчуудын дүрслэл” нэртэйгээр 2022 онд хэвлэн нийтлүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 27-нд Монголын Үндэсний төв музейд нээлт хийв.

Судалгааны ажлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажлын хүрээнд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Монголын угсаатан судлалын холбоо ТББ хамтран “Монголын Угсаатан судлал-2020” (1944-1990) сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 09 дүгээр сарын 16-нд зохион байгуулав. Хуралд ШУА, МУИС, МУБИС, МҮИС, Ховд Их сургууль, Монголын Үндэсний музей, Улаанбаатарын их сургууль, Япон улсын Васеда их сургууль зэрэг хүрээлэн, их дээд сургууль, музейн

судлаачид оролцож, нийт 16 илтгэл хэлэлцүүлэв. Хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдэд монголын угсаатны бүлгийн талаарх судалгааны сүүлийн үеийн судалгаа, соёлын биет бус өв, угсаатан судлалын шинжлэх ухааны хамааралтай хууль эрх зүйн заалтуудын талаар, уламжлалт шүтлэг бишрэл, тоглоом наадгай, малчдын бэлчээр ашиглалт зэрэг олон шинэ сонирхолтой баримт, санал дүгнэлтүүдийг дэвшүүлсэн нь судалгааны хувьд чухал ач холбогдолтой болсон юм. Хурлын үеэр судлаачид тус судалгааны ажлыг цаашид улам өргөжүүлэн, шинэлэг цогц байдлаар судлах шаардлагатайг онцлон тэмдэглэж байсан бөгөөд энэхүү хурал нь тухайн сэдвээр зохион байгуулсан анхны эрдэм шинжилгээний хурал болсон юм. Хурлын илтгэлүүдийг 2021 оны эхээр эмхэтгэн хэвлүүлж олны хүртээл болгосон нь энэхүү төслийн ажлын нэг гол үр дүн болж, олон нийтэд монголын угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжил, судалгааны үр дүнг танилцуулсан, сурталчилсан чухал ажил болсон юм.

2022 оны 09 сарын 16-нд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Ховд их сургуультай хамтран “Монголын угсаатан судлал-2022” Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Ховд аймгийн Ховд хотод зохион байгуулав. Тус хуралд Монгол, ОХУ-ын Тувагийн Бүгд найрамдах улс, БНХАУ-ын нийт 18 илтгэгч илтгэл хэлэлцүүлэв. Хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдэд монголын угсаатны бүлгийн талаарх судалгааны сүүлийн үеийн судалгаа, соёлын биет бус өв, хуулийн хүн судлал, монголчуудын овгийн судалгаа, малчдын бэлчээр ашиглалт зэрэг олон шинэ сонирхолтой баримт, санал дүгнэлтүүдийг дэвшүүлсэн нь судалгааны хувьд чухал ач холбогдолтой болсон юм. Хурлын үеэр судлаачид тус судалгааны ажлыг цаашид улам өргөжүүлэн, шинэлэг цогц байдлаар судлах шаардлагатайг онцлон тэмдэглэж байсан бөгөөд монголын угсаатан судлалын салбар ухааны цаашдын хөгжлийн талаар, үндэсний хэмжээний томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ойрын болон хэтийн зорилго, чиглэлийн талаар санал солилцов. Тус хурлын эмхэтгэлийг 2023 оны I улиралд хэвлэхээр редакторын уншилтад өгсөн.

Судалгааны үр дүнг хэвлүүлсэн байдал: Төслийн багийн гишүүн, доктор (Ph.D) Ч. Батдорж “ЗХУ-ын Монголын комиссын угсаатны зүйн чиглэлээр явуулсан судалгаа” сэдэвт өгүүллийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Угсаатан судлал” цуврал сэтгүүлийн 2020 оны дугаарт хэвлүүлэв. Мөн Ч. Батдорж “Шинжлэх ухааны хүрээлэнгийн төлөөлөгч Гэлэгдорж Увс аймагт ажилласан тухай”

сэдэвт өгүүллийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Угсаатан судлал” цуврал сэтгүүлийн 2020 оны дугаарт хэвлүүлэв.

Төслийн багийн гишүүн Г. Бямбарагчаа “Монголын дахь Угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжлийн тойм” сэдэвт өгүүллийг ШУА-аас эрхлэн гаргадаг Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүлийн 2022 оны дугаар хэвлүүлжээ. Мөн Г. Бямбарагчаа “Монгол дахь угсаатан судлалын ухааны түүхэн тойм: Дэг ба хөгжил” сэдэвт өгүүллийг Казахстан улсын Олон улсын Түрэг судлалын академиас эрхлэн гаргадаг “Altaistic, Turkology, Mongolistics” сэтгүүлийн 2020 оны № 4 дугаарт хэвлүүлэв. Төслийн багийн гишүүн Ч. Мөнхтөр “ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Нийгэм-соёлын хүн судлалын салбарын бүтэц, үйл ажиллагааны түүхэн тойм (1990-2020)” сэдэвт өгүүллийг ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Угсаатан судлал” цуврал сэтгүүлийн 2021 оны дугаарт хэвлүүлэв.

Дүгнэлт:

Төслийн судалгааны үр дүнд нэгэн сэдэвт хамтын бүтээл 1, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1, гэрэл зургийн катологи 2, өгүүлэл 5-г бичиж хэвлүүлэн нийтийн хүртээл болгов. Энэхүү үзүүлэлт нь гэрээнд заасан сэдэвт ажлын эцсийн үр дүнг бүрэн хангаж байгаа юм.

Сэдэвт ажлын шинжлэх ухаан, нийгмийн үндсэн ач холбогдол нь:

1. Монголын угсаатан судлалын шинжлэх ухааны түүхэн хөгжлийн талаарх асуудлыг анх удаа шинэлэг байдлаар гаргаж тавьснаар Монголын угсаатан судлалын түүхэн хөгжлийн талаарх суурь судалгааны төвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг буй болгосон.

2. Монголын угсаатан судлалын хөгжлийн түүхийн чиглэлээр үндсэн судалгааны баазыг шинэ эх хэрэглэгдэхүүнээр баяжуулсан.

3. Цаашид угсаатан судлалын ухааны хөгжлийн чиг хандлагын талаарх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад чухал түлхэц болж, түүхэн сургамжийг нээн харуулсан зэрэгт оршино.

Судалгааны үр дүнгээр гарсан бүтээлүүдийг бүх шатны сургалт, судалгаа, танин мэдэхүйн үйл ажиллагаанд ашиглах боломжтой юм.

Цаашид энэхүү судалгааны ажлыг үргэлжлүүлэх нь чухал байгаа бөгөөд цаашдын судалгааны чиг хандлагын талаар тогтмол хурал, хэлэлцүүлгийг хийж байх шаардлагатай бөгөөд үүний тулд “Монголын Угсаатан судлал” цуврал хурлыг тогтмол хийж, аль болох олон улсын эрдэмтэн судлаачдын санал хүсэлтийг тусгаж, монголын угсаатан судлалын ухааныг хөгжүүлэх баримт бичгийн эмхэтгэл гаргах шаардлагатай байна. Түүнчлэн монголын угсаатан судлалын чиглэлээрх судалгааны үр дүнг төрийн бодлого боловсруулах түвшинд хүргэх, судлаачдын санал дүгнэлтийг төрийн бодлогод хүргэх нь чухал байна. Тийм учраас цаашид монголын угсаатан судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүрээлэн, их дээд сургуулийн судлаачдын хамтарсан, үндэсний хэмжээний судалгаан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нь чухал байна. Ингэснээр Монголд угсаатан судлалын чиглэлийн нэгдсэн судалгааны бааз бий болж, судлаачдын онол үзэл баримтлалын нэг чигт бодлого бий болж, төр, хувийн хэвшлийн бүхий л түвшинд судлаачдын санал, үзэл бодлыг хүргэх зэрэг асуудлыг цогц байдлаар авч үзэх боломж бүрдэх талтай.

Суурь судалгааны сэдэвт ажлын үр дүнгээр хэвлэгдсэн бүтээлүүд

А. Нэгэн сэдэвт хамтын бүтээл

1. Г.Цэрэнханд, С. Чулуун. “Монголын угсаатан судлалын түүх” УБ., 2022. 15,3 х.х. “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэхээр хэвлэлд шилжүүлэхээр бэлэн болгож байна.

Б. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

1. “Монголын Угсаатан судлал-2020”. Эмхэтгэсэн: Г. Бямбарагчаа. УБ., 2020. 12,5 х.х. “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.
2. “Монголын Угсаатан судлал-2022”. Эмхэтгэсэн: Н. Мягмар. УБ., 2022. 12,5 х.х. хэвлэлд шилжүүлэхэд бэлтгэж байна.

В. Гэрэл зургийн цоморлиг

1. “Монгол малчдын нүүдэл, нутагшил”. Эрхэлсэн: Г. Цэрэнханд. УБ., 2022. 16,8 х.х. “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.
2. “Зургуудын дурсамж: ХХ зууны дунд үеийн Монголчуудын дүрлэл”. Эрхэлсэн: Г. Бямбарагчаа. УБ., 2022. 18,9 х.х. “Адмон принтинг” ХХК-д хэвлэв.

Г. Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Ч. Батдорж. “ЗХУ-ын Монголын комиссын угсаатны зүйн чиглэлээр явуулсан судалгаа” // “Угсаатан судлал”. УБ., 2020. тал 10-23.
2. Ч. Батдорж. “Шинжлэх ухааны хүрээлэнгийн төлөөлөгч Гэлэгдорж Увс аймагт ажилласан тухай” // “Угсаатан судлал”. УБ., 2021. тал 213-226.
3. Г. Бямбарагчаа. “Монгол дахь угсаатан судлалын ухааны түүхэн тойм: Дэг ба хөгжил” // “Altaistic, Turkology, Mongolistics” Нурсултан., 2020. № 4 тал. 110-119.
4. Ч. Мөнхтөр. “ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Нийгэм-соёлын хүн судлалын салбарын бүтэц, үйл ажиллагааны түүхэн тойм (1990-2020)” // “Угсаатан судлал”. УБ., 2021. тал 138-158.
5. Г. Бямбарагчаа. “Монголын дахь Угсаатан судлалын шинжлэх ухааны хөгжлийн тойм” // Шинжлэх ухаан амьдрал: УБ., 2022. тал 36-49.